



ХЭНГИЙ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 08 сарын 07 өдөр

Дугаар 5/92

Чингис хот

Ажилд шилжүүлэн томилох тухай

Төрийн албаны тухай Монгол Улсын хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалт, “Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын даргын тушаал гаргах журам /код-136/”-ийн 136.4.2-ийн “б” заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дүгээр тушаалаар батлагдсан “Алба хаагчийг шилжүүлэн ажиллуулах журам /код-908/”-ын 908.2.2-ийн “а” заалт, цагдаагийн газрын даргын зөвлөлийн 2017 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит 14 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүлжүүлэх, баривчлах байрны цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Лхагваагийн Сансарбаатарыг 2017 оны 08 дугаар сарын 07-ны өдрөөс үүрэгт ажлаас чөлөөлж, 2017 оны 08 дугаар сарын 08-ны өдрөөс Батноров сум дахь сум дундын цагдаагийн тасагт жижүүрийн цагдаагаар шилжүүлэн томилсугай.

2. Цагдаагийн ахлах ахлагч Л.Сансарбаатарын албан тушаалын үндсэн цалинг Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 332 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан цалингийн шатлалын ТТ-7-5 дугаар шатлал 592266 төгрөгөөр, цолны нэмэгдлийг 25 хувиар, онцгой нөхцөлийн нэмэгдлийг 25 хувиар, алба хаасны нэмэгдэлийг 15 хувиар тус тус бодож олгохыг ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч Ж.Баатарт зөвшөөрсүгэй.

3. Шилжин томилогдсон цагдаагийн ахлах ахлагч Л.Сансарбаатарын ажлын байрыг хүлээлцүүлэх, албан тушаалтай нь холбоотой хууль, дүрэм, журам, эрх зүйн актуудыг танилцуулан судлуулах, мөрдүүлэх, цаг ашиглалт, сахилга ёс зүйн байдалд тогтмол хяналт тавьж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицох хөтөлбөр хэрэгжүүлэх журам /код-912/-ын дагуу богино хугацаанд ажилд нь сургаж, дадлагажуулан биелэлт үр дүнг тооцож ажиллахыг Батноров сум дахь сум дундын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч Д.Баасандоржид үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга, цагдаагийн хошууч Т.Чинбаатарт даалгасугай.

5. Тушаалын хуулбарыг хувийн хэрэгт нь хавсаргахыг Хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн ахмад П.Алтантуяад үүрэг болгосугай.

6. Тушаалыг нийт бүрэлдэхүүнд танилцуул.

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА



Ж.БОЛД